

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хангах, сахин хамгаалах, хүндэтгэх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, хөхиүлэн дэмжих, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хүний эрхийн Үндэсний Комиссын хууль тогтоомж

2.1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“хүний эрх, эрх чөлөө” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан боломжийг;

3.1.2.“хүний эрхийг хангах” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц нийгэм, эдийн засаг, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх төрийн үүргийг;

3.1.3.“хүний эрхийг хамгаалах” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх төрийн үүргийг;

3.1.4.“хүний эрхийг хүндэтгэх” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөнд

харшлах шийдвэр гаргахгүй, үйл ажиллагаа явуулахгүй, бусад хэлбэрээр саад учруулахгүй байх төрийн болон бусад этгээдийн үүргийг;

3.1.5.“Хүний эрхийн үндэсний байгууллага” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллагыг;

3.1.6.“эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа” гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан механизмыг;

3.1.7.“хүний эрхийн зөрчил” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг төр, түүний байгууллага, хуулийн этгээдийн зөрчсөн буюу төрөөс хамааралтай үйлдэл, эс үйлдэхүйг;

3.1.8.“хүний эрхийг хөхиүлэн дэмжих” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтийн хүний эрхийн боловсролыг түгээх, хүний эрхийн түгээмэл соёлыг төлөвшүүлэх, олон улсын гэрээнд нэгдэн орох явдлыг дэмжихэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг;

3.1.9.“хүний эрхийг сахин хамгаалах” гэж хүний эрхийн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, шалгах, шийдвэрлэх, хүний эрхийн хяналт шалгалт явуулах, хүний эрхийн зөрчлийг арилгуулахаар шаардлага, зөвлөмж хүргүүлэх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг;

3.1.10.“хүний эрхийн хяналт шалгалт” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргээ төрийн байгууллага, хуулийн этгээд хэрхэн биелүүлж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогц үйл ажиллагааг;

3.1.11.“хүний эрхийн боловсрол” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний агуулгыг бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх албан болон албан бус боловсрол олгох үйл ажиллагааг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

4 дүгээр зүйл.Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх зарчим

4.1.Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, үйл ажиллагаа нь хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэхэд чиглэсэн байна. Хүний эрхийг хангах,

хамгаалах, хүндэтгэх чиг үүргийг бүх төрийн байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлнэ.

4.2.Төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад Хүний эрхийн үндэсний байгууллага энэ хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавьж ажиллана.

4.3.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, захиргааны шийдвэр гаргахдаа энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасныг баримтлана.

4.4.Энэ зүйлийн 5.1-д заасан байгууллагууд хуулиар олгогдсон чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх зарчмыг удирдлага болгоно.

5 дугаар зүйл.Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо

5.1.Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгч, бүх шатны шүүх, Үндсэн хуулийн цэц, бүх шатны төрийн байгууллагууд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Хүний эрхийн үндэсний байгууллагаас бүрдэнэ.

5.3.Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд иргэний ниймийн байгууллагыг оролцуулж болно.

6 дугаар зүйл.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

6.1.Монгол Улсад Хүний эрхийн үндэсний байгууллагын чиг үүргийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /цаашид Комисс гэх/ хэрэгжүүлнэ.

6.2.Комисс төсвөөс санхүүжнэ. Комиссын дарга Комиссын төсвийн төслийг хянуулахаар Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд оруулна. Хууль зүйн байнгын хороогоор хянагдаж зөвшөөрөгдсөн төсвийн төслийг улсын төсөвт нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлнэ.

6.3.Төсөв нь Комиссын үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх бөгөөд уг төсөвт хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, хөхиүлэн дэмжих, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэх, тусгай мэдлэг шаардагдсан тохиолдолд албан тушаалтныг шинжээчээр томилоход шаардагдах хөрөнгийг тусгана.

6.4.Комиссын нийт төсвийн төлөвлөлт, зарцуулалтад Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо хяналт тавина.

6.5.Комисс нь үйл ажиллагаа явуулах өөрийн байртай байна.

6.6.Комисс бэлгэдэл, тамга, тэмдэгтэй байх бөгөөд төрийн сүлд бүхий хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

7 дугаар зүйл.Комиссын чиг үүрэг

7.1.Комисс дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргаж эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

7.1.2.хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх, тэдгээрийг боловсронгуй болгох талаар санал гаргах;

7.1.3.олон улсын хүний эрхийн гэрээнд нэгдэн орох явдлыг дэмжих, олон улсын хүний эрхийн гэрээний биелэлтийг хангуулах талаар шаардах, Засгийн газрын илтгэлд санал, зөвлөмж өгөх;

7.1.4.бүх нийтийн хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх;

7.1.5.хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалах;

7.1.6.хүний эрхийн салбарт олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

7.1.7.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлийг Улсын Их Хуралд өргөн барих.

8 дугаар зүйл.Комиссын үйл ажиллагааны үндсэн зарчим

8.1.Комисс нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, хүртээмжтэй байх, бодитой байх, шударга, ил тод байх зарчмыг баримтлана.

8.2.Аливаа байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, хувь хүн Комисс, түүний гишүүний үйл ажиллагаанд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

9 дүгээр зүйл.Комисс Монгол Улсын Их Хуралтай харилцах

9.1.Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлийг жил бүр Улсын Их Хуралд тайлагнана.

9.2.Комиссын илтгэлийг Улсын Их Хурлын тухайн жилийн хаврын чуулганаар хэлэлцэж, илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурал шийдвэр гаргана.

9.3.Комиссын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд Улсын Их Хурал зохих бүтцээрээ дамжуулан хяналт тавина.

10 дугаар зүйл.Комисс Засгийн газартай харилцах

10.1.Засгийн газар Комиссын төсвийг энэ хуулийн 6.2-6.3-т заасан журмын дагуу саналыг боловсруулж Улсын Их Хуралд мэдүүлнэ.

10.2.Комиссын гишүүн Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд Ерөнхий сайдын хүсэлтээр Хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлаар зөвлөх эрхтэйгээр оролцож болно.

10.3.Комисс олон улсын хүний эрхийн гэрээнд нэгдэн орох асуудлаар байр сууриа илэрхийлэх, Монгол Улсын олон улсын хүний эрхийн гэрээний биелэлтийг хангуулах талаар шаардах, Засгийн газрын илтгэлд санал, зөвлөмж өгнө.

11 дүгээр зүйл.Прокурорын байгууллагатай харилцах

11.1.Комисс болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан нөхцөлийн талаар статистик мэдээллийг прокурорын байгууллагын гаргуулж авах эрхтэй.

12 дугаар зүйл.Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, томилох

12.1.Комиссын гишүүнд нэр дэвшигч нь дараахь шаардлагыг хангасан гучин таван насанд хүрсэн Монгол Улсын иргэн байна:

- 12.1.1.хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй;
- 12.1.2.хүний эрхийн асуудлаар мэдлэг, туршлагатай;
- 12.1.3.ял шийтгүүлж байгаагүй.

12.2.Комисс гурван гишүүнтэй байна.

12.3.Нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгохоос гучаас доошгүй хоногийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын Дээд шүүх нь Комиссын гишүүний сул орон тооны талаар олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж энэ зүйлийн 12.1-д заасан шаардлагыг хангасан иргэдийн өргөдлийг хүлээн авна.

12.4.Энэ зүйлийн 12.3-т заасны өргөдөл хүлээн авах хугацаа дууссанаас хойш 10 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын Дээд шүүх энэ зүйлийн 12.1-д заасан шаардлагыг хангасан иргэдээс сонгож, тус бүр хоёроос дээшгүй нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгоно.

12.5.Санал болгосон нэр дэвшигчийг Улсын Их Хурлын дарга ажлын арав хоногийн дотор холбогдох Байнгын хороонд танилцуулж, хэлэлцүүлнэ.

12.6.Улсын Их Хурал нэр дэвшигчийг Комиссын гишүүнд томилохоос татгалзсан бол Улсын Их Хурлын дарга арван дөрвөн хоногийн дотор энэ хуулийн 14.1-д заасан журмын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

12.7.Улсын Их Хурал нэр дэвшигчийг татгалзсан тохиолдолд тухайн хүний нэрийг дахин дэвшүүлж болохгүй.

12.8.Нэр дэвшигчийн нэрийг өргөн мэдүүлснээс хойш гуч хоногийн дотор Улсын Их Хурал уг асуудлыг хэлэлцэн, шийдвэрлэж, гишүүнийг томилно.

12.9.Комиссын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанаас өмнө хуульд заасан үндэслэлээр албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, огцорсон, нас барсан тохиолдолд Улсын Их Хурал жар хоногийн дотор энэ хуульд заасны дагуу Комиссын гишүүнийг нөхөн томилно.

12.9.Комиссын гишүүн сургалт, эрдэм шинжилгээний ажил хийхээс бусад энэ хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв гишүүн томилогдохоосоо өмнө өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөнө.

13 дугаар зүйл.Комиссын дарга болон гишүүний бүрэн эрхийн хугацаа

13.1.Комиссын гишүүний нэгэн бүрэн эрхийн хугацаа зургаан жил байна.

13.2.Комиссын гишүүний бүрэн эрх Монгол Улсын Үндсэн хуульд тангараг өргөснөөр эхэлж, Комиссын шинээр томилогдсон гишүүн тангараг өргөснөөр дуусгавар болно.

13.3.Комиссын гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.

13.4.Комиссын даргаар сонгох хүний нэрийг Комиссын гишүүд хууль зүй, хүний эрх, төрийн удирдлагын чиглэлээр туршлагатай гишүүнийг дотроосоо дэвшүүлэн хуралдаанаараа хэлэлцэж, саналыг нууцаар хурааж нийт гишүүний олонхийн санал авсан хүнийг сонгоно.

13.5.Комиссын даргын бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.

13.6.Комиссын даргын түр эзгүйд Комиссын бүрэлдэхүүнд хамгийн удаан ажилласан гишүүн, хэрэв энэ шаардлагыг хэд хэдэн гишүүн нэгэн адил хангасан байвал тэдгээрийн хамгийн ахмад гишүүн Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэнэ.

14 дүгээр зүйл.Комиссын гишүүн тангараг өргөх

14.1.Комиссын гишүүн томилогдсоноосоо хойш гуч хоногийн дотор “Би Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Монгол Улсын хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, сахин хамгаалах үүргээ чин шударгаар биелүүлэхээ батлан тангараглая.” хэмээн Монгол Улсын Үндсэн хуульд тангараг өргөнө.

14.2.Комиссын гишүүний тангараг өргөх ёслолыг Төрийн албаны тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

15 дугаар зүйл.Комиссын гишүүнийг чөлөөлөх, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах

15.1.Дараахь тохиолдолд Улсын Их Хурал Комиссын гишүүнийг албан тушаалаас нь чөлөөлнө:

15.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Төлөөлөгчдийн сонгуульд нэрээ дэвшүүлэхээр хүсэлт гаргасан;

15.1.2.өөр албан тушаалд томилогдсон, эсхүл сонгогдсон;

15.1.3.биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос өөрөө хүсэлт гаргасан.

15.2.Комиссын гишүүн эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан, түүнчлэн энэ хуулийн 39.1-д заасны дагуу баривчлагдсан бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг энэ тухай эрх бүхий байгууллагын гаргасан санал, шийдвэрийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэнэ.

15.3.Комиссын гишүүн гэмт хэрэгт холбогдолгүй, гэм буруугүй болохыг тогтоосон эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэн түүний бүрэн эрхийг сэргээж Улсын Их Хурал тогтоол гаргана.

15.4.Комиссын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноор түүнийг албан тушаалаас нь огцруулж Улсын Их Хурал тогтоол гаргана.

16 дугаар зүйл.Комиссын гишүүдийн хуралдаан

16.1.Комиссын дарга, гишүүд сар тутам хуралдах ба шаардлагатай тохиолдолд Комиссын дарга ээлжит бус хурлыг тухай бүр зарлан хуралдуулж болно.

16.2.Комиссын хуралдааны дэгийг Комиссын өөрөө тогтооно.

16.3.Энэ хуулийн 7.1-д заасан Комиссын чиг үүрэгт хамаарах дараахь асуудлыг Комиссын хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

16.3.1.Комиссын ажлын албаны дүрмийг баталж, орон тоо, цалингийн санг Улсын Их Хурлаас баталсан төсөвт багтаан тогтоох;

16.3.2.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлийн бүтэц, агуулга, илтгэлээр өгөх санал, зөвлөмжийг хэлэлцэж, шийдвэрлэх;

16.3.3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх саналыг хэлэлцэх;

16.3.4.Комиссын стратегийн болон үйл ажиллагааны жил, улирал, сарын ажлын чиглэлийг тодорхойлох;

16.3.5.хяналт шалгалт, судалгааны нэгдсэн дүнг хэлэлцэх;

16.3.6.хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой цаг үеийн шинжтэй асуудлаар нийтэд илэрхийлэх Комиссын нэгдмэл байр суурийг тодорхойлох;

16.2.7.Комиссын дэргэд иргэний нийгмийн зөвлөлийн ажиллах дүрмийг батлах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ КОМИССЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

17 дугаар зүйл.Комиссын гишүүний бүрэн эрх

17.1.Комиссын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.тухайлан хариуцаж байгаа хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа талаарх мэдээллийг үндэслэн өөрийн санаачлагаар, эсхүл байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, иргэний хүсэлтээр шалгалт хийх;

17.1.2.хүний эрхийн асуудлаар судалгаа хийх зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтнаас бүх төрлийн баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, шаардлагатай мэдээлэл, судалгаа гаргуулан авах;

17.1.3.хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомж, түүний төслийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;

17.1.4.шаардлагатай асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр судалгаа хийлгэх, тухайлсан асуудлаар мэргэшсэн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;

17.1.5.хүний эрхийн асуудлаар аливаа этгээдэд зөвөлгөө өгөх.

18 дугаар зүйл.Комиссын даргын эрх, үүрэг

18.1.Комиссын дарга дараахь эрх, үүрэгтэй:

18.1.1.Комиссыг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

18.1.2.Улсын Их Хурлын чуулган, Засгийн газрын хуралдаанд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлаар зөвлөх эрхтэй оролцох;

18.1.3.Комиссын нэгдмэл байр суурийг илэрхийлэх;

18.1.4.Комиссын гишүүдийн хариуцах хүний эрхийн чиглэлийг тодорхойлох;

18.1.5.Комиссын ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх;

18.1.6.Комиссын дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;

18.1.7.Комиссын дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам баталж мөрдүүлэх;

18.1.8.Комиссын хуралдааныг товлож, удирдан хуралдуулах;

18.1.9.Комиссын цахим шуудан болон утсаар гомдол хүлээж авах, хариу өгөх журмыг батлах;

18.1.10.Комиссын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмыг батлах.

18.1.11.эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

19 дүгээр зүйл.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэл

19.1.Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн барина.

19.2.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлийн сэдвийг Комиссын хуралдаанаар шийдвэрлэнэ.

19.3.Комиссын илтгэлийг Улсын Их Хурлын тухайн жилийн хаврын чуулганаар хэлэлцэж, илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурал шийдвэр гаргана.

19.4.Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолд заасан үүргийн дагуу Комиссын илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэнээ Улсын Их Хурлын тогтоол гарснаас хойш 6 сарын дотор тайлагнана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ КОМИССТ ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ, ШАЛГАХ, ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

20 дугаар зүйл.Комисст гомдол, мэдээлэл гаргах эрх

20.1.Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөө зөрчсөн талаар Монгол Улсын иргэн дангаар, эсхүл хамтарч энэ хуульд заасны дагуу Комисст гомдол гаргах эрхтэй.

20.2.Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний адил Комисст гомдол гаргах эрх эдэлнэ.

20.3.Хүүхэд болон иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй, зарим, эсхүл хэсэгчилсэн чадамжтай хүн өөрт хамаарах аливаа асуудлаар бие даан гомдол гаргах эрхтэй бөгөөд тэдгээрийг төлөөлөн хууль ёсны төлөөлөгч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гомдол гаргаж болно.

20.4.Сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүний хуульд заасан төлөөлөгч нь гомдол гаргаж болно.

20.5.Ашгийн төлөө бус хуулийн этгээд энэ зүйлийн 20.1-д заасан эрхийг мөн адил эдлэх бөгөөд төлөөлөгчөөрөө дамжуулан гомдол, мэдээлэл гаргана.

20.6.Ашгийн төлөө бус хуулийн этгээд энэ хуулийн 21, 22 зүйлд заасан журмын дагуу мэдээлэл гаргана.

20.7.Энэ зүйлийн 20.3, 20.4, 20.5-д заасан төлөөлөгч нь өөрийн бүрэн эрхийг нотолсон баримт бичигтэй байна.

21 дүгээр зүйл.Гомдол гаргах хэлбэр

21.1.Гомдлыг монгол хэлээр бичгээр, эсхүл амаар гаргана. Монгол хэл мэдэхгүй хүн эх хэлээрээ гомдол гаргаж болох бөгөөд гомдлоо монгол хэлнээ орчуулж, зохих журмаар баталгаажуулсан байна.

21.2.Амаар биечлэн гаргасан гомдлыг хүлээн авахдаа гомдлын талаар тэмдэглэн авч, гомдол гаргагчаар гарын үсэг зуруулна. Хэрэв гомдол гаргагч нь бичиг, үсэг мэдэхгүй болон хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэж, гомдлыг хүлээн авна.

21.3.Гомдлыг Комиссын цахим шуудан, эсхүл тусгайлан ажиллуулсан утсаар гаргаж болно.

22 дугаар зүйл.Гомдолд тавих шаардлага

22.1.Гомдолд дараахь зүйлийг тусгасан байна:

22.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан ямар эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн болохыг заах;

22.1.2.гомдол гаргагч эцэг /эх/-ийн нэр, нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаараа бичиж, гарын үсгээ зурсан байх;

22.1.3.зөрчигдсэн эрх, эрх чөлөө, болсон нөхцөл байдлын талаар тодорхой дурдаж, нотлох баримтыг хавсаргасан байх;

22.1.4.гомдолд холбогдож байгаа байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, түүний удирдлага, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар холбогдох бусад баримтыг хавсаргасан байх.

22.2.Комиссын гишүүн эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэрэг, маргааны талаарх гомдлыг хүлээн авахгүй ба энэ нь эрүү, иргэн, зөрчил, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтнаас Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх гомдлыг хүлээн авахад хамаарахгүй.

22.3.Комисс нэр, хаяггүй гомдол хүлээн авахгүй.

23 дугаар зүйл.Гомдол гаргах болон хянан шийдвэрлэх хугацаа

23.1.Гомдол гаргагч Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн өдрөөс, эсхүл тийнхүү зөрчигдсэн гэдгийг мэдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор гомдлоо гаргана.

23.2.Комисс гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх ба нэмэлт судалгаа, шалгалт хийх шаардлагатай бол Комиссын дарга дахин 30 хүртэл хоногоор сунгаж болно.

23.3.Гомдлыг долоо хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтанд харьяаллын дагуу шилжүүлнэ.

23.4.Комисс нь гомдол гаргагчийн нууцлалыг чандлан хадгална.

24 дүгээр зүйл.Комиссын гишүүний гомдол хүлээн авахтай холбогдсон бүрэн эрх

24.1.Комиссын гишүүн гомдол хүлээн авахтай холбоотой дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.гомдлыг хүлээн авч, хянан үзэх;

24.1.2.энэ хуулийн 22 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй гомдлыг хүлээн авахаас татгалзах;

24.1.3.гомдол гаргагчид зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаар тайлбарлах.

25 дугаар зүйл.Комиссын гишүүний гомдол шалгахтай холбогдсон бүрэн эрх

25.1.Комиссын гишүүн гомдол шалгахтай холбоотой дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.гомдол гаргагч, холбогдох байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, түүний удирдлага, хувь хүнээс гомдлын талаар бичгээр болон амаар тайлбар авах;

25.1.2.гомдол гаргагч, холбогдох хүмүүсийг дуудан ирүүлэх;

25.1.3.гомдолтой холбогдолтой асуудлаар аль ч байгууллага, хуулийн этгээдэд саадгүй нэвтрэн орж, холбогдох албан тушаалтантай биечлэн уулзах;

25.1.4.шаардлагатай нотлох баримт, албан бичиг, мэдээллийг байгууллага албан тушаалтан, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авах, газар дээр нь танилцах;

25.1.5.тусгай мэдлэг шаардагдсан тохиолдолд шүүхийн шинжилгээний байгууллагаар болон бусад байгууллагын шинжээчийг томилж, дүгнэлт гаргуулах;

25.1.6.байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дангаар, эсхүл төрийн эрх бүхий байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд санал болгосны үндсэн дээр хамтран шалгалт хийх;

25.1.7.тухай гомдолтой холбоотой хуульд заасан журмын дагуу төрийн болон албаны, хувь хүний нууцтай танилцах.

26 дугаар зүйл.Комиссын гишүүний гомдол шийдвэрлэхтэй холбогдсон бүрэн эрх

26.1.Комиссын гишүүн гомдол шийдвэрлэхтэй холбоотой дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1.хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд шаардлага, зөвлөмж хүргүүлэх;

26.1.2.байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, хувь хүн хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах;

26.1.3.хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн этгээдэд холбогдох хариуцлага оногдуулах тухай саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;

26.1.4.талуудыг эвлэрүүлэн зуулчлах замаар гомдлыг шийдвэрлэх;

26.1.5.гомдол нь эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэрэг, маргааны шинжтэй гэж үзвэл түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтанд харьяаллын дагуу шилжүүлэх;

26.1.6.зөрчлийг арилгах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд зөрчил арилгуулахаар гомдлыг шилжүүлэх, биелэлтийг шаардах;

26.2.Комиссын гишүүн албан үүргээ гүйцэтгэх явцад түүнд илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, хувь хүний нууцыг чандлан хадгална.

26.3.Энэ зүйлийн 26.1.2-т заасны дагуу гаргасан нэхэмжлэл улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.

26.4.Комиссын гишүүн гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хуульд заасан журмын дагуу гомдол гаргагчид хариу мэдэгдэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ КОМИССЫН ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖ

27 дугаар зүйл.Комиссын гишүүн шаардлага, зөвлөмж гаргах

27.1.Комиссын гишүүн нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлага, зөвлөмж гаргана.

27.2.Комиссын гишүүн нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл тухайн хүний эрх, эрх чөлөөг сэргээж, зөрчлийг арилгуулахаар холбогдох хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтанд шаардлага хүргүүлнэ.

27.3.Комиссын гишүүн нь хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй гэж үзвэл шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлнэ.

28 дугаарзүйл.Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг биелүүлэх

28.1.Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан заавал биелүүлэх үүрэгтэй.

28.2.Шаардлагыг хүлээн авснаас хойш хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан гуч хоногийн дотор, зөвлөмжийг хүлээн авсан бол 60 хоногийн дотор авсан арга хэмжээнийхээ тухай бичгээр хариу мэдэгдэнэ. Комиссын гишүүн хүний эрхийн зөрчил, хэрэгжүүлэх арга хэмжээний онцлогоос хамааран хариу мэдэгдэх хугацааг өөрөөр тогтоож болно.

28.3.Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн дагуу арга хэмжээ аваагүй нь албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, аж ахуйн нэгжийн хувьд тусгай зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг нь зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

28.4.Комиссын гишүүн нь гаргасан шаардлага, зөвлөмж, түүний хэрэгжилтийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх, олон нийтэд мэдээлэх эрхтэй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ КОМИССЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

29 дүгээр зүйл.Комиссын ажлын алба

29.1.Комисс ажлын албатай байна. Комиссын ажлын алба нь Комиссын гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүй, хүний нөөцийн дэмжлэг үзүүлэх чадавхи бүхий мэргэшсэн алба байна.

29.2.Ажлын алба нь Комиссын чиг үүргийг дагнан хэрэгжүүлэх газар, хэлтэстэй байна.

29.3.Комиссын ажлын албаны дарга, ажилтан төрийн захиргааны албан хаагч байна.

29.4.Комиссын ажлын алба нь орон нутагт Комиссын чиг үүргийг хэрэгжүүлэх орон тооны ажилтантай байна.

29.5.Комиссын орон нутаг дахь ажилтны үйл ажиллагаанд Ажлын алба хяналт тавина.

29.6.Комиссын гомдол, хяналт шалгалт хариуцсан нэгж байна.

29.7.энэ зүйлийн 29.6-д заасан нэгж Комиссын гишүүний бүрэн эрхийг түүний нэрийн өмнөөс дараахь байдлаар төлөөлөн хэрэгжүүлнэ.

29.7.1.гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх;

29.7.2.Комиссын гишүүний удирдамж, чиглэлийн дагуу гомдлыг шалгах, баримтжуулах;

29.7.3.гомдлыг шалгаад тогтоогдсон нөхцөл байдлыг саналын хамт Комиссын гишүүнд танилцуулах;

29.7.4.Комиссын гишүүний удирдамж, чиглэлийн дагуу хүний эрхийн хяналт шалгалт явуулах;

29.7.5.Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих.

29.8. Энэ зүйлийн 29.7.5-т заасны дагуу явуулж байгаа гомдол, хяналт шалгалт хариуцсан ажилтны үйл ажиллагаанд гомдол, хяналт шалгалт хариуцсан нэгжийн удирдлага хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангана.

30 дугаар зүйл.Иргэний нийгмийн зөвлөл

30.1.Комисс нь үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий иргэний нийгмийн зөвлөлтэй байна.

30.2.Иргэний нийгмийн зөвлөлийн олон талт төлөөллийг хангахдаа хүний эрхийн асуудал эрхэлсэн ашгийн төлөө бус хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаачдыг оролцуулна.

30.3.Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн дараахь шаардлагыг хангасан байна:

30.3.1.хүний эрхийн асуудал эрхэлсэн ашгийн төлөө бус хуулийн этгээдийн гишүүн байх, эсхүл эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш судлаач байх;

30.3.2.хүний эрхийн чиглэлээр сүүлийн 3 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан, эсхүл судалгаа, шинжилгээний ажил эрхэлсэн байх;

30.3.4.ял шийтгүүлж байгаагүй байх;

30.3.4.улс төрийн намын харьяалалгүй байх, намын гишүүн бол түүнээс түдгэлзсэн тухай шийдвэр гарсан байх.

30.4.Иргэний нийгмийн зөвлөлийн ажиллах дүрмийг Комиссын хуралдаанаар баталж мөрдүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГАА

31 дүгээр зүйл.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа

31.1.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн хэрэгжүүлнэ.

31.2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн нь төсөв, үйл ажиллагааны хувьд Комиссын гишүүнээс хараат бус байна. Комиссын гишүүн нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцох эрхгүй.

31.3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.

31.4.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг дараа оны эхний улиралд Улсын Их Хуралд танилцуулна.

32 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн

32.1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүнийг энэ хуулийн 12.3-12.8-т заасан журмын 3 жилийн хугацаатай дагуу томилж, чөлөөлнө.

32.3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүнээр хууль зүй, эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаа, хүний эрхийн асуудлаар мэдлэг, туршлагатай, ёс зүйн хувьд төлөвшсөн, ял шийтгэлгүй Монгол Улсын иргэнийг томилно.

32.4.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүнээр төрийн улс төрийн албан хаагч, улс төрийн намын удирдах болон гүйцэтгэх албан хаагч, Комиссын гишүүн, албан хаагч, бүх шатны шүүгч, прокурор, мөрдөгчийг томилохыг хориглоно.

32.5.Эрүү шүүлтээс гишүүнийг энэ хуулийн 15.1-д заасан үндэслэлээр хугацаанаас өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүрэг

33.1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

33.1.1.аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх;

33.1.2.олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг ухуулан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах;

33.1.3.эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах;

33.1.4.хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах.

Тайлбар:-Энэ зүйлийн 33.1.1-д заасан “бүх газарт” гэдэгт хорих байгууллага, урьдчилан хорих анги, хүүхдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсэдийн байрыг ойлгоно.

34 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний бүрэн эрх

34.1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

34.1.1. аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт газарт саадгүй нэвтрэх, хяналт шинжилгээ хийх;

34.1.2. энэ зүйлийн 34.1.1-д заасан газар, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн талаарх бүх төрлийн мэдээллийг аль ч үед гаргуулан авах;

34.1.3. энэ зүйлийн 34.1.1-д заасан газарт ажиллахдаа аюулгүй байдлаа хангуулах;

34.1.4. энэ зүйлийн 34.1.1-д заасан газарт ажиллахдаа нөхцөл байдлыг техник хэрэгсэл ашиглан баримтжуулах;

34.1.5. эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

34.1.6. эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашгийн төлөө бус хуулийн этгээд болон бусад байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох, олон нийтэд тогтмол мэдээллэх;

34.1.7. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

34.1.8. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн даргыг томилох, чөлөөлөх;

34.1.9. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;

34.1.10. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам баталж мөрдүүлэх.

35 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний зөвлөмж

35.1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн нь хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж болзошгүй гэж үзвэл шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлнэ.

35.2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний зөвлөмжийг хүлээн авсан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

35.3. Зөвлөмжийг хүлээн авсанаас хойш хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан 30 хоногийн дотор авсан арга хэмжээнийхээ тухай бичгээр хариу мэдэгдэнэ.

35.4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ аваагүй нь албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, хуулийн этгээд, байгууллын хувьд хувьд үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

36 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж

36.1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүнд туслах чиг үүрэг бүхий зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны нэгж ажиллана.

36.2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дарга, ажилтан төрийн захиргааны албан хаагч байна.

36.3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж нь Комиссын ажлын албанд харьяалагдах ба зөвхөн энэ хуулийн 33.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ КОМИСС БОЛОН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН БАТАЛГАА

37 дугаар зүйл. Улс төрийн баталгаа

36.1. Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн болон ажлын албаны ажилагсад улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Гишүүн албан тушаал хаших хугацаандаа улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.

37.2. Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

38 дугаар зүйл.Эдийн засаг, нийгмийн баталгаа

38.1.Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

38.2.Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлдээ тохирсон цалин авна.

39 дүгээр зүйл.Хууль зүйн баталгаа

39.1.Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь эсхүл хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад хорин дөрвөн цагийн дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих болон зөрчлийн шийтгэл ногдуулах, гэр, албан өрөө, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

39.2.Хуульд зааснаас бусад тохиолдолд Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүнийг ажлаас чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

39.3.Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

39.4.Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хуулийн этгээд, байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, иргэд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

40 дүгээр зүйл.Аюулгүй байдлын баталгаа

40.1.Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан амь нас, эрүүл мэндэд нь бодит аюул заналхийлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага аюулгүй байдлыг хангана.

40.2.Хүний эрхийн хяналт шинжилгээ, хяналт шалгалтын үеэр Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн, ажлын албаны ажилтнуудын аюулгүй байдлыг шалгалтад хамрагдаж байгаа байгууллага, албан тушаалтан хангана.

40.3.Хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний тавьсан хууль ёсны шаардлагыг хувь хүн, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

41 дүгээр зүйл.Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүнд хориглох зүйл

41.1.Комисс болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтаас гадна дараахь зүйлийг хориглоно:

41.1.1.сургалт, эрдэм шинжилгээний ажил хийхээс бусад энэ хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;

41.1.2.энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглах;

41.1.3.албан үүрэгтэй нь холбогдож, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, хувь хүний нууцыг задруулах;

41.1.4.Монгол Улсын олон улсын гэрээгээр болон бусад улсын хүний эрхийн үндэсний байгууллага, олон улсын байгууллагатай харилцан тохиролцсоноос өөр гадаад улс, гадаад улсын аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр гадаад улсад зорчих.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

42 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

42.1.Энэ хуулийг 2019 оны дугаар сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.